



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 649

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 51,150,000.00 (тавин нэгэн сая нэг зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ, 47,799,921.86 (дөчин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун хорин нэгэн төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
649 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРААС БАЯНГОЛ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тоёота Камри, 74-05 УБЗ, 6Т1BF9FK5DX435758, Суудлын автомашин	2013/2013	7850	51,150,000.00	47,799,921.86	3,350,078.14
НИЙТ ДҮН						
				51,150,000.00	47,799,921.86	3,350,078.14
				(тавин нэгэн сая нэг зуун тавин мянган)	(дөчин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун хорин нэгэн төгрөг наян зургаан мөнгө)	(гурван сая гурван зуун тавин мянга далан найман төгрөг арван дөрвөн мөнгө)